

**“МИНИЙ ДАГЕСТАН” БОЛ ЭССЕ НИЙТЛЭЛИЙН
ШИЛДЭГ БҮТЭЭЛ МӨН**

Д. Батжаргал*

Түлхүүр үг: *Эссе, түүнд тавигдах шаардлага, гадаадын болон монголын судлаач, эрдэмтдийн тодорхойлолт, бүтээлийн талаар үнэлэлт, дүгнэлт*

Дагестаны ардын яруу найрагч Расул Гамзатовын “Миний Дагестан”-ыг монголын их соён гийгүүлэгч, гүүш М.Цэдэндорж орчуулан нэг, хоёрдугаар дэвтрийг нийлүүлэн 1980 онд Улаанбаатар хотноо хэвлүүлжээ. Яруу сайхан орчуулсан номын агуулга бүхэлдээ, эх орон, элгэн садандаа хайртай найрагч, түүний уран бүтээлдээ хандах хандлага, зохиолчийн хүнд агаад жаргалтай, баяр баясгалантай хөдөлмөр, дагестаны ард түмний амьдрал, сэтгэл, аман зохиолын өв санг мэдрэхэд чиглэжээ. Нэрнээсээ эхлээд эссе нийтлэлийн амин сүнс болсон “Би” баатар өгүүлнэ.

Эссе нь францын “essais” буюу өөрийгөө турших, сонжих, хувийн найруулга, бодол цэгнүүр гэсэн утгатай болохыг судлаачид олонтаа тэмдэглэжээ. Анхны үүсэл нь ч ийм юм. Асар их уншдаг номон дунд л хамаг өдрийг бардаг Монтень ойр дотныхондоо дотоод сэтгэлээ нээж харуулах зорилгоор туурвисан урьд хэн ч бичиж байгаагүй этгээд сонин хэлбэр бүхий, эртний суут зохиогчид хийгээд түүх домгоос хэдэн зуугаар ишилсэн гойд сонирхолтойн дээр маш уйгагүй нарийн хөдөлмөр шаардсан эргэцүүлүүдээ “Les Essis” хэмээн нэрлэсэн нь мөн л “туршиц, туршлагаууд” гэсэн утгатай байлаа. “Туршилтын” эсээнүүдийн эхний хоёр дэвтэр 1580, гутгаар нь 1588 онд хэвлэгдсэн¹ аж.

Тэгвэл “Миний Дагестан” номд найрагчийн хувийн дэг найруулга, авар хэмээх жижигхэн үндэстний Цада гэдэг хот айлаас төрсөн алдартай уран бүтээлч, Дагестаны ардын яруу найрагч Гамзат Цадаса, түүний хүү Расул Гамзатов нарын ертөнцийг үзэх үзэл, уран бүтээлийнх нь эх ундарга болсон уулынхны домог хууч шог яриа цөм багтжээ. Хараалд ч гэсэн яруу сайхан хэллэг байдгийг цогцлоон гаргасан байна.

Эссе бусад бичвэрийн төрлөөс ялгагдах онцлог нь нэг зүйлийг олон талаас нь авч үздэг, тиймээс нэгийг уншихад арвыг мэдрүүлэх агуулгатай байдаг гэж тэмдэглэдэг. Энэ нь олон ухааны уулзвар зааг нийлц дээр бичдэгтэй холбоотой. Уг шаардлага “Миний Дагестан”-ы бүлэг \хоёр бүлэгтэй\, хэсэг бүрт байдаг. Нэгдүгээр бүлгийн “Авьяас” гэсэн хэсэгт \номын 177-200 дугаар тал\ “Яруу найрагч, алтан загас хоёрын

* МУИС-ийн МХСС-ийн Утга зохиолын тэнхим

¹ “Сонгомол эсээнүүд” /Орч Г.Аюурзана/, Улаанбаатар, 2005, 7 дугаар тал.

тухай шог үг”, “Эцэг ярьсан нь”, “Би нэг нөхрөө гомдоосон түүх”, “Авьяастай бол хөгшин ч хамаагүй”, “Би Изяд хэлнэ”, “Хэний зургийг тавих вэ?”, “Абуталиб болоод Хатиматын тухай шог үг”, “Миний эцэг ярьсан нь”, “Тэмдэглэлийн дэвтрээс”, “Эцгийн дуртгалаас” гэсэн арван баримтыг хооронд нь нягт уялдуулан холбож бичжээ. Олны дунд яригддаг зүйгуул үгээс эхлээд болсон явдал, амьдралын жишээ, онолын үнэлэлт дүгнэлт гэж хэлж болохуйц эргэцүүлэл цөм багтжээ.

“За Авьяасаа, хэлж өгөөч, чиний хүч чухамдаа юундаа байнам бэ?. Авьяасаа чи чухамдаа нинжин сэтгэл, нэр төр, чин зориг уу, аль эсхүл айдас уу. Аймхай хүн шөнө хээр явахдаа өөрийгөө зоригжуулан дуулдаг шүү дээ. Авьяас гэгч жаргал юм уу, зовлон юм уу, шагнал юм уу, шийтгэл юм уу, эсхүүл хүмүүсийг шаналаах гэж бүтсэн гайхамшиг юм уу, эсхүл сайн сайхныг төрүүлдэг зовлон юм уу, эсхүүл чи цаг үе, үйл явдлын үрс үү? Хоёр чулууг хооронд нь харшуулахад гал гардаг. Дайн гэгч орчлон дээр хүн нэмдэггүй авч орчлон дээр баатар нэмдэг. Яруу найраг гэж юу байдгийг би хэлж мэдэхгүйн адил авьяас гэж юу байдгийг хэлж чадахгүй”² гэж бичжээ. Ийнхүү бодол эргэцүүллээ хэсэг бүртээ шигтгэж уншигчийг бодуулах, санал сэтгэгдэлээ нээхэд гол анхаарлаа хандуулсан байна.

Профессор Д.Галбаатар “Эссе шинэ сонирхолтой санаа бодол, тодорхойллыг уншигчдын өмнө тавьж, түүх, гүн ухаан, намтар судлал, гарал зүй, уран зохиолын нийтлэл, шүүмжлэл, шинжлэх ухааны хялбаршуулсан зохиол, угсаатны судалгааны хэлбэрээр зохиогддог. Уран зохиол, сэтгүүл зүйн бичлэгийн арга найруулгыг нэгтгэсэн байдгаараа онцлог юм”³ тодорхойлжээ. Энд хэлсэнчлэн уран зохиол, сэтгүүл зүйн найруулгын арга барилыг нэгтгэсэн байдал илт мэдрэгдэнэ. Яруу найрагч Расул Гамзатовын олон жилийн тэмдэглэл энд бий. Жишээ нь,

Тэмдэглэлийн дэвтрээс: *“Бельгид олон үндэсний төлөөлөгч цугларсан дэлхийн яруу найрагчдын уулзалтад очлоо. Хувь заяа намайг аль ч нутагт аваачсан ялгаагүй хот айлын төлөөлөгч гэж өөрийгөө ямагт бодож явдаг. Хаа явсан газар болгондоо би өөрийгөө Дагестаны тусгай сурвалжлагч гэж тооцдог. Дагестандаа би бүх хүн төрөлхтний соёлын тусгай сурвалжлагч, нийт манай орон түүгээр ч үл барам бүх дэлхийн төлөөлөгч болж буцаж ирнэ”* гэх мэтээр бичсэн хэсгүүд нэн олон. Сэтгүүл зүйн тэмдэглэлийн төрлөөс гадна, ярилцлага, хөрөг дэх дүрслэл, сурвалжлагын элементүүд өч төчнөөн бий.

Цада Гамзатын захидалд “Хоол хийх гэж тулганд гал түлэх, бас сууцныхаа хананд үхрийн баас шавдаг хүүхэн хүн, манай Абуталибын том малгай шиг утаа байшингийн дээвэр дээрээс олгойдохыг би энэ Москвад олж үзсэнгүй. Дээвэр засдаг бул чулуу олж харсангүй. Москвагийнхан дээвэр дээрээ өвс хатаахыг олж үзсэнгүй. Тэд өвс хатаадаггүй ахул, үхрээ юугаар тэжээдэг байна? Өвс юм уу, мөчир баглаад явж байгаа хүүхэн нэгийг ч олж харсангүй” гэж өгүүлж байна. Захидал ч гэсэн сэтгүүл зүйн болон уран зохиолын аль алиных нь төрөл. Ц.Дамдинсүрэнгийн “Буурал ээж минь”, Ж.Пүрэвийн “Мянган захидал”, Ш.Дулмаагийн “Хүүгийн эцэгт бичсэн захидал”, Стефан Цвейгийн “Танихгүй эмэгтэйн захидал” гээд олон сайн бүтээлийг тоочиж болно.

Дэлхийн утга зохиолын нэр томьёоны толь бичигт “Эссег ямар нэгэн тодорхойлолтод хамруулж үл болно” гэж үзсэн бол Оросын судлаач Энштейн эссег

²) Гамзатов Р, “Миний Дагестан”, /Орч М.Цэдэндорж/, Улаанбаатар, 1980, 195 дугаар тал.

³) Галбаатар Д, “Уран зохиол” /нэвтэрхий толь/, Улаанбаатар, 2012, 540 дүгээр тал.

төрөл зүйлийнхээ хязгаараас үргэлж хальдаг дотоод мөн чанартай гэж тайлбарласан байна. Сэтгүүл зүйн бичлэгийн төрөл зүйлүүдийг мэдээллийн, шинжлэлт, нийтлэл уран сайхны хэмээн гурван том бүлэгт хуваагаад зүйлчлэн үзэхэд эссег шинж чанараар нь нийтлэл уран сайхны төрөлд багтаасан байдаг. Тэгвэл “Миний Дагестан”-д нийтлэл уран сайхны шинж олон бий. Шүлэг бичээгүй байж зохиолч болох гээд далбагар том дайвар захиатай ирдэг яруу найрагч Махмудын ач ямар гэнэн юм бэ? гэж бодогдох хэсэг байхад яруу найрагчийн дотоод ертөнц, хайр дурлалын агууд бишрэх зүйл өч төчнөөн тааралдана. Уншигч та зарим хэсэгт нь хөнгөхөн мушийж, зарим хэсэгт нь баясч, зарим хуудсан дээр санааширч, зарим хэсэгт учиргүй догдлон баярлах биз. Ерөөс уулынхны зан араншин, дотоод ертөнц нэвт шувт харагдана.

Эссе ямар нэгэн асуудлын талаарх бодит, онолын мэдлэг биш хувь уран бүтээлчийн үзэл бодол эргэцүүлэмж, төсөөлөл, таамаглалыг шингээсэн юмс үзэгдлийн мөн чанар, шалтгаан, холбоо хамаарлыг заавал баталж, нотолж бичих албагүй тухайн өгүүлэмжид холбогдох мэдээллийг цуглуулах өргөн боломж бүхий чөлөөт бичлэгийн хэв маяг.

...Суугаа хүний хөлтэй хөлгүйг мэдэхгүй

Дуугүй хүний хэлтэй хэлгүйг мэдэхгүй

Унтаа хүний нүдтэй нүдгүйг мэдэхгүй... гэх юм уу,

Хамгийн сайн ваарыг жирийн шавраар хийдэг

Хамгийн сайн шүлгийг энгийн үгээр бичдэг... гэх мэт сонгомол мөрүүд яруу найргийн амт шимтийг мэдрүүлэхийн зэрэгцээ, тухайн хэсгийн хэлэх санааны тодотгол болж байна.

Миний шавь нэгэн оюутан “Багшийн тухай ертөнцийн хязгаарт” эссе бичлэгтээ “*Багш аа би бороонд дуртай. Та бол надад,*

Зун орохгүй

Зуунд норгохгүй бороо...

Тиймээ үнэн урсах хязгааргүйгээс зүрхэн дээр минь унах үгэн дуслууд тань тархины минь гүн дэх залхуурал хэмээгчийг угааж тунгалаг бодлуудыг тунаруулах нь би төөрч явсан мэт. Та аливаа амжилтын 99 хувь нь хөдөлмөр, ганицхан хувь нь авъяас гэж хэлэх дуртай байдагсан. Гэвч би оюутан болоод залхуурлыг шүтсэн мэт. Тэр намайг жаргааж бас амралт өгч байсан юм шиг. Уг нь ажил хийсэн хүн л амардагсан. Хийсвэр гэдгийг нь мэдсээр өөрийгөөн хууран байж хийх энэ үйлдэл “Сонгодог амралт” гэмээр бүтээл аятай.

Гутал муут

Гурван хүний ард

Ааши муут

Арван хүний ард хэмээн, нийгэмд хүн өөрийгөө яаж авч явах, хүний гадаад дотоод төрх яаж нөлөөлдгийг энэ мэтээр энгийн атлаа хатуу жишээ татаж хэлж өгдөгсөн”⁴ гэсэн оюутны бүтээлд залуу хүний эмзэглэл, сэтгэлгээ зовнил байгаа бол оюутан Б.Амарчимэг “*Би бол би... Цор ганц... Давтагдашгүй нэгэн эмзэг дэлбээ... Харахад энгийн нэгэн байдаг л охин. Гаднаа илэн далангүй, хаа хамаагүй, чөлөөтэй байдаг юм шиг боловч дотроо бас л бусдын адил өөрийн гэсэн бодолтой нэгэн. Миний дотоод ертөнцийг, мөрөөдөл төсөөллийг хэн ч мэдэхгүй... Би өөрийнхөөрөө л байхыг хүсдэг. Бусдын ая талыг засаж далбаан дор нь намирна гэдэг миний хувьд байж*

⁴) Амарбаясгалан Г, /МУИС-ийн МХСС-ийн утга зохиолын судлаачаар 2010 онд төгсөгч/, 2009 оны гар бичмэл.

боломгүй бүтэхгүй хэрэг. Таалагдахгүй л бол юу ч байсан хаях хэрэгтэй гэж боддог...”⁵ хэмээн “Би” эсседээ бичжээ. Хоёр оюутны бүтээлийн бичлэг хэллэг сайн байгаа ч тэд маань бие хүн болж амжаагүй болохоор ялимгүй хүч муутай мэт. Гэтэл Расул Гамзатов хэн билээ. Лениний шагналт, Социалист хөдөлмөрийн баатар Расулыг зөвхөн социалист систем \хуучнаар\-ийн орнууд төдийгүй дэлхий дахинаар мэдэх билээ. Эссе бичигч олны танил бие хүн байвал илүү хүчтэй, үлдэцтэй “дуу хоолой” болохсон билээ. Энэ чанар “Миний Дагестанд” цогцолж, үндэсний үзэл, яруу найрагчийн ертөнцийг нээх түлхүүр болсон нь дамжиггүй. Тиймээс яах аргагүй бие хүний дуулал, яруу найрагчийг нээсэн нээлт болж байна. Ном хэвлэгдснийхээ дараахан орос, зөвлөлтийн утга зохиолын ертөнцөд дуулиан шуугиан тарьж байсан билээ. Энэ ч чанаруудаараа эссе бичлэгийн шилдэг бүтээл хэмээн үзэхэд хүргэж байна.

Ном зүй

1. “Сонгомол эсээнүүд” (2005), Орч Г.Аюурзана, Улаанбаатар.
2. Гамзатов Р (1980), “Миний Дагестан”, Орч М.Цэдэндорж, Улаанбаатар.
3. Галбаатар Д (2012), “Уран зохиол” /нэвтэрхий толь/, Улаанбаатар.
4. Амарбаясгалан Г (2009), /МУИС-ийн МХСС-ийн утга зохиолын судлаачаар 2010 онд төгсөгч/, гар бичмэл.
5. Амарчимэг Б (2011), /МУИС-ийн МХСС-ийн утга зохиол судлаачийн 3 дугаар ангийн оюутан/, гар бичмэл.

SUMMARY

This finely translated book aims, as a whole, to create an understanding of the author's love for his home country and its people, his approach his literary works, the difficult and enjoyable work involved in being a writer, and the life, mentality, and oral literature of the Dagestani people.

⁵⁾ Амарчимэг Б, /МУИС-ийн МХСС-ийн утга зохиол судлаачийн 3 дугаар ангийн оюутан/, 2011 оны гар бичмэл.